ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Дархан цаазат газрын Дорнод хамгаалалтын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2025/104/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг
Утас: 88883776 Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025. 02. 24 № 237

танай 2025. 01. 27-ны № 24 -т

ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН ДОРНОД ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГА Х.ДАШДОРЖ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан цаазат газрын Дорнод хамгаалалтын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Дархан цаазат газрын Дорнод хамгаалалтын захиргааны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 5 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 89.1 хувьтай үнэлсэн байна.

01102203

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **180,451,960.31** | **238,390,690.45** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 20,000,000.00 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | - | 20,000,000.00 |
| **3121** | **Төгрөг** | - | 20,000,000.00 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | - | 20,000,000.00 |
| **33** | **АВЛАГА** | 157,900.00 | - |
| **335** | **Бусад авлага** | 157,900.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 157,900.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 180,294,060.31 | 218,390,690.45 |
| **351** | **Түүхий эд материал** | - | - |
| **354** | **Хангамжийн материал** | 169,694,060.31 | 203,720,690.45 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,095,641.00 | 11,152,741.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 164,598,419.31 | 192,567,949.45 |
| 35600 | Мал амьтад | 10,600,000.00 | 14,670,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **552,079,121.77** | **471,665,079.61** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | - | - |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 552,079,121.77 | 471,665,079.61 |
| 391 | Газар | - | - |
| **392** | **Биет хөрөнгө** | 517,141,121.77 | 435,459,146.28 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 203,659,912.06 | 203,659,912.06 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (30,981,333.70) | (37,380,673.54) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 479,721,919.20 | 479,721,919.20 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (319,847,069.27) | (345,204,161.27) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 119,670,570.79 | 119,670,570.79 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (25,393,679.60) | (44,883,911.60) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 30,687,537.11 | 31,587,537.11 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (12,855,620.32) | (19,900,803.65) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 117,561,812.50 | 117,561,812.50 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (45,082,927.00) | (69,373,055.32) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 34,938,000.00 | 36,205,933.33 |
| 39301 | Програм хангамж | 600,000.00 | 1,867,933.33 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (600,000.00) | (600,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 34,938,000.00 | 34,938,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **732,531,082.08** | **710,055,770.06** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **157,900.00** | **4,980,115.48** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 157,900.00 | 4,980,115.48 |
| **413** | **Өглөг** | 157,900.00 | 4,980,115.48 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 4,556,379.08 |
| **4136** | **Бусад өглөг** | 157,900.00 | 423,736.40 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 423,736.40 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **732,373,182.08** | **705,075,654.58** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 732,373,182.08 | 705,075,654.58 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 143,013,553.48 | 143,013,553.48 |
| 51101 | Өмч: - төрийн | 143,013,553.48 | 143,013,553.48 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 443,251,830.58 | 415,954,303.08 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 443,251,830.58 | 443,251,830.58 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (27,297,527.50) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 146,107,798.02 | 146,107,798.02 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **732,531,082.08** | **710,055,770.06** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,104,605,199.27** | **991,218,133.33** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **322,800,699.27** | **63,828,933.33** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 322,800,699.27 | 63,828,933.33 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 322,800,699.27 | 43,828,933.33 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,906,000.00 | 1,759,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 315,894,699.27 | 42,069,933.33 |
| 120009 | Бусад орлого | - | 20,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **781,804,500.00** | **927,389,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 721,722,000.00 | 893,095,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 721,722,000.00 | 893,095,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 60,082,500.00 | 34,294,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 4,100,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,750,000.00 | 8,874,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 54,232,500.00 | 25,420,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **846,545,453.68** | **1,018,515,660.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **846,545,453.68** | **1,018,515,660.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 617,299,109.95 | 890,424,245.92 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 379,329,108.91 | 649,187,020.09 |
| 210101 | Үндсэн цалин | 229,561,441.41 | 355,153,558.37 |
| 210102 | Нэмэгдэл | 71,965,428.55 | 153,988,569.32 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 36,871,000.00 | 100,317,650.00 |
| 210104 | Урамшуулал | 40,931,238.95 | 39,727,242.40 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 47,500,628.09 | 77,876,641.93 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,710,361.34 | 53,438,808.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,819,651.13 | 6,294,871.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,033,716.58 | 3,290,528.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 747,830.54 | 2,970,486.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,189,068.50 | 11,881,946.80 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 5,935,429.27 | 8,943,957.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 998,142.91 | 1,275,652.28 |
| 210302 | Түлш, халаалт | 3,928,890.36 | 3,935,294.27 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,008,396.00 | 733,011.00 |
| 210304 | Байрны түрээс | - | 3,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 43,383,855.87 | 22,902,834.86 |
| 210401 | Бичиг хэрэг | 962,150.00 | 1,292,707.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,250,000.00 | 12,960,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,255,259.00 | 1,313,858.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 23,916,446.87 | 7,336,269.86 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,697,000.00 | 8,150,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,697,000.00 | 7,850,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,958,700.00 | 5,615,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,958,700.00 | 5,615,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 30,139,681.00 | 21,827,116.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 28,661,020.00 | 18,610,820.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 195,200.00 | 2,031,660.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 209,000.00 | 238,836.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 110,000.00 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 428,000.00 | 561,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 86,461.00 | 307,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 94,354,706.81 | 95,921,375.49 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,990,000.00 | 10,600,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,239,400.00 | 2,739,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 79,125,306.81 | 82,581,975.49 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 229,246,343.73 | 128,091,414.91 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,690,000.00 | 75,175,703.80 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 10,690,000.00 | 15,010,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 60,165,703.80 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 218,556,343.73 | 52,915,711.11 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 218,556,343.73 | 52,915,711.11 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | <u>258,059,745.59</u> | <u>(27,297,527.50)</u> |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | <u>258,059,745.59</u> | <u>(27,297,527.50)</u> |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **<u>788,710,500.00</u>** | **<u>949,148,200.00</u>** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,906,000.00** | **21,759,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 6,906,000.00 | 21,759,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 6,906,000.00 | 1,759,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,906,000.00 | 1,759,000.00 |
| 120009 | Бусад орлого | - | 20,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **781,804,500.00** | **927,389,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 721,722,000.00 | 893,095,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 721,722,000.00 | 893,095,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 60,082,500.00 | 34,294,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 4,100,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,750,000.00 | 8,874,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 54,232,500.00 | 25,420,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **<u>744,110,500.00</u>** | **<u>929,148,200.00</u>** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **744,110,500.00** | **929,148,200.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **514,864,156.27** | **801,056,785.09** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 379,329,108.91 | 644,206,904.61 |
| 210101 | Үндсэн цалин | 229,561,441.71 | 350,173,442.89 |
| 210102 | Нэмэгдэл | 71,965,428.25 | 153,988,569.32 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 36,871,000.00 | 100,317,650.00 |
| 210104 | Урамшуулал | 40,931,238.95 | 39,727,242.40 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 47,500,628.09 | 77,876,641.93 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,710,361.34 | 53,438,808.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,819,651.13 | 6,294,871.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,033,716.58 | 3,290,528.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 747,830.54 | 2,970,486.67 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,189,068.50 | 11,881,946.80 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 6,285,429.27 | 8,943,957.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 998,142.91 | 1,275,652.28 |
| 210302 | Түлш, халаалт | 3,928,890.36 | 3,935,294.27 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,358,396.00 | 733,011.00 |
| 210304 | Байрны түрээс | 00.00 | 3,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24,256,709.00 | 20,901,465.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 962,150.00 | 1,282,207.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,250,000.00 | 12,960,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,255,259.00 | 1,355,858.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,789,300.00 | 5,303,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,797,000.00 | 18,946,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,100,000.00 | 10,196,000.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 900,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,697,000.00 | 7,850,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,958,700.00 | 5,615,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,958,700.00 | 5,615,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 30,139,681.00 | 21,827,116.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 28,661,020.00 | 18,610,820.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 195,200.00 | 2,031,660.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 209,000.00 | 238,836.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 110,000.00 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 428,000.00 | 561,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 86,461.00 | 307,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,596,900.00 | 2,739,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,596,900.00 | 2,739,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **229,246,343.73** | **128,091,414.91** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10,690,000.00 | 75,175,703.80 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 10,690,000.00 | 15,010,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 60,165,703.80 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 218,556,343.73 | 52,915,711.11 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 218,556,343.73 | 52,915,711.11 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **44,600,000.00** | **20,000,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **44,600,000.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **44,600,000.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 44,600,000.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 44,600,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(44,600,000.00)** | **-** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 20,000,000.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 20,000,000.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/төгрөгөөр/**

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **143,013,553.48** | **146,107,798.02** | **443,251,830.58** | **732,373,182.08** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **143,013,553.48** | **146,107,798.02** | **443,251,830.58** | **732,373,182.08** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (27,297,527.50) | (27,297,527.50) |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **143,013,553.48** | **146,107,798.02** | **415,954,303.08** | **705,075,654.58** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **893,695,200.00** | **841,938,488.89** | **51,756,711.11** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **893,695,200.00** | **841,938,488.89** | **51,756,711.11** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **833,173,800.00** | **781,772,785.09** | **51,401,014.91** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **686,389,600.00** | **644,206,904.61** | **42,182,695.39** |
| 210101 | Үндсэн цалин | 350,190,900.00 | 350,173,442.89 | 17,457.11 |
| 210102 | Нэмэгдэл | 171,817,100.00 | 153,988,569.32 | 17,828,530.68 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 102,586,800.00 | 100,317,650.00 | 2,269,150.00 |
| 210104 | Урамшуулал | 61,794,800.00 | 39,727,242.40 | 22,067,557.60 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **85,798,700.00** | **77,876,641.93** | **7,922,058.07** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,343,200.00 | 53,438,808.75 | 4,904,391.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,863,900.00 | 6,294,871.33 | 569,028.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,431,900.00 | 3,290,528.38 | 141,371.62 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,431,900.00 | 2,970,486.67 | 461,413.33 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,727,800.00 | 11,881,946.80 | 1,845,853.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **10,036,700.00** | **8,943,957.55** | **1,092,742.45** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,297,000.00 | 1,275,652.28 | 21,347.72 |
| 210302 | Түлш, халаалт | 4,800,100.00 | 3,935,294.27 | 864,805.73 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 939,600.00 | 733,011.00 | 206,589.00 |
| 210304 | Байрны түрээс | 3,000,000.00 | 3,000,000.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **18,167,400.00** | **18,087,965.00** | **79,435.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,307,200.00 | 1,282,207.00 | 24,993.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,960,000.00 | 12,960,000.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,410,300.00 | 1,355,858.00 | 54,442.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,489,900.00 | 2,489,900.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,027,500.00** | **5,025,800.00** | **1,700.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,880,000.00 | 2,880,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 2,147,500.00 | 2,145,800.00 | 1,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,415,000.00** | **4,415,000.00** | **-** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,415,000.00 | 4,415,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **20,599,500.00** | **20,477,116.00** | **122,384.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,611,000.00 | 18,610,820.00 | 180.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 695,300.00 | 681,660.00 | 13,640.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 347,400.00 | 238,836.00 | 108,564.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 77,000.00 | 77,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 561,000.00 | 561,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 307,800.00 | 307,800.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,739,400.00** | **2,739,400.00** | **-** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,739,400.00 | 2,739,400.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **60,521,400.00** | **60,165,703.80** | **355,696.20** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **-** | **-** | **-** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **60,521,400.00** | **60,165,703.80** | **355,696.20** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 60,521,400.00 | 60,165,703.80 | 355,696.20 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | - | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | - | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **893,695,200.00** | **841,938,488.89** | **51,756,711.11** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **893,695,200.00** | **841,938,488.89** | **51,756,711.11** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 893,095,200.00 | 840,179,488.89 | 52,915,711.11 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 600,000.00 | 1,759,000.00 | (1,159,000.00) |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** | **-** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **20,000,000.00** | **(20,000,000.00)** |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **23.00** | **22.00** | **1.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 17.00 | 16.00 | 1.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 | - |

## 2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5.5 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс, аудитын явцад 5.5 сая төгрөгийн алдааг залруулллаа.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

*Залруулсан алдаа:*

- Бараа материалын шинжтэй 1.4 сая төгрөгийн хөрөнгийг шууд зардалд тайлагнасныг орлого болгож залруулав. Энэ нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Байгууллагын даргын тушаалгүй 4.1 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг данснаас хассаныг буцаан орлогодож залруулав. Энэ нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 10.2 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс 10.2 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**2.1 Албан шаардлага**

1. Хоол, унааны хөнгөлөлтийг өдрийн 14.0 мянган төгрөгөөр илүү тооцоолон, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй нийт 6.2 сая төгрөгийг 22 ажилтанд олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогч, нярав нар тус бүр 160.0 хувиар тооцон 4.0 сая төгрөгийг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчин Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор тогтоосон урамшууллын хэмжээг хэтрүүлэн олгосон, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа материалын шинжтэй хөрөнгийг шууд зардалд тайлагнасан: | 1 | 1,473.0 | | | | | 1 | 1,473.0 | | | | |
| Байгууллагын даргын тушаалгүй эргэлтийн хөрөнгийг данснаас хассан. | 1 | 4,070.0 | | | | | 1 | 4,070.0 | | | | |
| **Дүн** | **2** | **5,543.0** | | | | | **2** | **5,543.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хоол, унааны хөнгөлөлтийг анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар тооцон олгосон | 1 | 6,230.0 | | | 1 | 6,230.0 | | | | | | |
| Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогч, нярав нар тус бүр 160.0 хувиар тооцон олгосон | 1 | 4,020.2 | | | 1 | 4,020.2 | | | | | | |
| **Дүн** | **2** | **10,250.2** | | | **2** | **10,250.2** | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант жилд 2 мэдээллийг хугацаа хоцроосон байна. | 1 | - | | | | | 1 | - |
| **Нийт дүн** | **1** | **-** | | | | | **1** | **-** |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр | Дугаар 165/19125799 ДОА-2025/104/НА-СТА-ТШЗ | Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан цаазат газрын Дорнод хамгаалалтын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус газрын ажиллагсдад олгосон хоол, унааны зардлыг 12 сард ажлын нэг өдөрт 14,000.00 төгрөгөөр буюу нийт 6,230,000.00 төгрөгөөр илүү тооцон олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 " Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 8.4-д "Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/37 тоот тушаалын 1-д "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдад олгох хоол, унааны зардлын хэмжээг ажлын нэг өдөрт 12,000 /арван хоёр мянган/ төгрөг байхаар шинэчлэн баталсугай" гэж зааснbг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх *"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/37 тоот тушаалын хэрэгжилтийг мөрдөн ажиллах, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040258

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Дархан цаазат газрын Дорнод хамгаалалтын захиргааны дарга Х.Дашдорж, нягтлан бодогч М.Ганболор нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НАНДИНЧИМЭГ

2117144066

ХТҮ4037 9030891

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр | Дугаар 2Ш/19125799 ДАА-2025/101/НА-СТЛ-ТШЗ | Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан цаазат газрын Дорнод хамгаалалтын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогч, нярав нарт 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 4,020,160.00 төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн *6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн *15.1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;* Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д *"Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна"* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх *"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2125040254

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Дархан цаазат газрын Дорнод хамгаалалтын захиргааны дарга Х.Дашдорж, нягтлан бодогч М.Ганболор нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НАНДИНЧИМЭГ